

**МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО ЗОХИОЛ ДАХЬ
ТОДОСГОГЧ НЭГЖИЙН УТГА, ҮҮРЭГ**

Г.Бямбацэрэн
/МУБИС/

Товч агуулга:

Монголын нууц товчоо (МНТ) дахь тодосгогч нэгжийг шүүн үзэхэд утгыг хязгаарлах үүрэгтэй, ерөнхий ба тодорхойг ялгах үүрэгтэй, жишин адилтгасан, утгыг эрчимжүүлсэн үүрэгтэй, хандсан үгийн үүрэгтэй, онцолбор гишүүний үүрэгтэй, найруулгын үүрэгтэй, баймж утгыг илэрхийлэх үүрэгтэй гэж ангилж болох бөгөөд хэлбэрийн хувьд үг, нийлмэл үг, өгүүлбэр, эхийн бүтцээр илэрч буйг эш татах боломжтой бөгөөд зарим нэг өвөрмөц ялгаа бүхий тодосгогчийн “хэрэглээ” байгааг хэл-сэтгэлгээг түшиж тайлбарлахыг зорилоо. МНТ зохиолд урнаар шүлэглэж дүрслэн тодосгосон жишээ цөөнгүй байх ба энэ нь монгол хэлний яруу, баялаг шинжийг тодотгохын сацуу ихэвчлэн ойролцоо зэргэдийн шинжтэй.

Түлхүүр үг: тодруулах, лавшруулах, өргөмж нэр, оноосон нэр, хорших, монгол сэтгэлгээ, онцолбор, ялгах ёс

Монгол хэлний хийсвэр шинжтэй хэлэх ба ухаарах нь төсөөлөл, уран сэтгэмж, зөн совин, таамгаас эх үүдэлтэйг, түүнчлэн Ч.Эрдэнийн тодорхойлсон “Хаос нь хосолмол чанарыг агуулж байдаг”, хэлний их нэгж нь бага нэгжээ багтаадаг нь ёс боловч үүнээс урваж бага нь ихийгээ багтаадаг байна. Үүнийг хэлэн дэх эмх замхгүй ёс (хаосизм) гэнэ. Энэ нь хэлний хөдлөнги шинжээс үүсэж буй урвуу үзэгдэл гэснээс тодосгуулагч, тодосгогчийн харьцаа хэлэн дэх хаосизмыг харуулах, монгол хэлний тодосгогч, тодосгуулагчийн харьцаа мөн хэлэн дэх тэгш хэм (симметрия) гэдгийг харуулах нь өгүүлбэр судлалын чухал зорилтуудын нэг болж байгааг сонгодог бүтээл дээр жишээлэн тайлбарлахыг зорилоо.

Монгол хэлний тодосгогч нэгжийн утга, үүргийг бичгийн болон аман эхийн хэрэглээнд үндэслэн Т.А.Бертагаев, Ш.Лувсанвандан Ш.Барайшир, М.Базаррагчаа, Б.Пүрэв-Очир нар судлан тодочлогч, тодотгол, тодруулагч зэрэг хэл шинжлэлийн ойлголтуудаас ангид авч үзэн, хэлний цуваа бүтэц дэх нэгжүүдийн утга, санаа, хэлбэрийг өөрчлөн давтсан давталт гэж тодорхойлжээ.

Тодосгогч нь мэдэгдэхүүн ба хэлэгдэхүүн талаасаа хэлц бус (бүхэл зүйжсэн) холбоо үүсгэдэг. Нэг утга, хоёр өөр хэлбэр гэсэн харьцаа үүсгэдгээрээ хаослаг шинжтэй хэлэхүүн үзэгдэл юм.

Монголын нууц товчоо (МНТ) дахь тодосгогч нэгжийг шүүн үзэхэд утгыг хязгаарлах үүрэгтэй, ерөнхий ба тодорхойг ялгах үүрэгтэй, жишин адилтгасан, утгыг эрчимжүүлсэн үүрэгтэй, хандсан үгийн үүрэгтэй, онцолбор гишүүний үүрэгтэй, найруулгын үүрэгтэй, баймж утгыг илэрхийлэх үүрэгтэй гэж ангилж

болох бөгөөд хэлбэрийн хувьд үг, нийлмэл үг, өгүүлбэр, эхийн бүтцээр илэрч буйг эш татах боломжтой бөгөөд зарим нэг өвөрмөц ялгаа бүхий тодосгогчийн “хэрэглээ” байгааг хэл-сэтгэлгээг түшиж тайлбарлахыг зорилоо. МНТ зохиолд урнаар шүлэглэж дүрслэн тодосгосон жишээ цөөнгүй байх ба энэ нь монгол хэлний яруу, баялаг шинжийг тодотгохын сацуу ихэвчлэн ойролцоо зэргэдийн шинжтэй. Тухайлбал:

Харь улсыг үл тэмцэн,
Хацар гоо охидыг
Хаан болсонд та нарын
Хасаг тэргэнд унуулж
Хар буур хөлгөж
Хатируулж одож
Хатан сууринд
Хамт суулгамуй, бид.
*(Улс иргэнийг үл тэмцэн
Өнгө сайд охидоо өсгөж
Өлжигтэй тэргэнд унуулж
Өл буур хөлгөж
Үүсгэж одож
Өндөр сууринд
Өрөөл этгээд суулгахуй, бид)*^{тодосгогч}

Ойролцоо утгатай зэргэдүүд дэх утга ч бас нэгэн хэлбэрийн давталт бөгөөд хэлэхийн нэг санааг өөр хэлбэрээр давтсан давталт юм. Зэргэдүүд нь ойролцоо утгатай нэгжүүд хоршсон нэгжүүд үүсгэдэг ба мэдээлэх, харилцах утга нь ижил. Гэхдээ зэргэд болгон тодосгогч болохгүй бөгөөд зүйрлэсэн зэргэдүүд тодосгогч, тодосгуулагчийн харьцаа үүсгэхгүй. Ойролцоо утгатай үгийг МНТ-д хоршин хэрэглэсэн нь цөөнгүй бөгөөд ийнхүү хорших нь шууд ба буцах холбоотой байнга хувьсан өөрчлөгдөх (динамик) шинжтэй бөгөөд нөгөө талаас аяндаа цэгцрэх (өөрийгөө зохицуулах) шинжтэй.

Гадаад ертөнц хэлэн дэх ертөнц нь эх болохдоо байж болох бүх шинжүүдээр дэлгэрч сэтгэхүйн ертөнцөд боловсрогдоно. Тэр үед хэлэгдэхүүний нэг хэлбэр-дохио хосолдог байна. Сэтгэхүй дэх энэ боловсруулалт хоршсон хэлэгдэхүүний нэгжийг бий болгож хэлийг баяжуулдаг. Хоршсон үг, нэгж аажмаар “сонгогдох” зарчмаар битүү бүтцээ алдан харилцах, мэдээлэхэд онцлогдсон, чухалчлагдсан бүрдүүлэгч нь үлдэнэ. Энэхүү үлдсэн дохио хэлэгдэхүүний нэг нэгж дахин болж улмаар дахин дэлгэрүүлэх, тайлбарлахтай холбоотойгоор дахин хоршсон битүү цэгцтэй бүтэц үүсгэж болно. Үүнээс үндэслэн тодосгогч, тодосгуулагчийн хосолсон хэрэглээ (сэтгэлгээ) ойролцоо утгатай хоршоо үгийг бий болгосон. Хоршоо үгийн утгын ойролцоо болон авианы ойролцоо байдлыг харгалзан тухайн эхийн үг өгүүлбэр, цогцолборыг харшуулан ойртуулах, толгой сүүл холбох, мөр бадаг тэнцүүлэх зэрэг найруулах эрдмийг монголчууд чадамгай ашигладгийн жишээг МНТ-ны хэлээс харж болно.

МНТ тодосгогчууд, тоогоор тодосгосон, оноосон нэр, өргөмж нэр, ойролцоо зэргэд (хоршсон хэлбэр), оруулбар шинжтэй тодосгогчууд олонтоо. Хураан

тодосгосон жишээг авч үзвээс... Алтан ээмэг, дөрөвчит булгаар доторлосон таж *торгон* элгэвчит өчүүхэн хөвүүхнийг авчирч Чингис *хаан* Өгээлүн *эхэд сауха* өгөв. (МНТ, 81т)

Ялган, хурааж тодосгосон, тодосгохдоо тодосгуулагч онцолбор гишүүдийг илрүүлсэн. Түүнчлэн Чингисийн байлдан дагууллын үе дэх саухаг тоочиж утгыг дэлгэрүүлж, хураан тодосгосноор тодосгогч гишүүн дэлгэрүүлэх бус хураах үүрэг гүйцэтгэдгийг, монголчуудын эрхэмлэх ёс, эдлэл чимэглэл, түүгээр дамжуулан язгуур гарвалийг харуулсан байх.

Жамуха өгүүлрүүн: “Тэмүжин *анд, анд!*

Уул шахан бууя.

Адуучин, бидний

Алагчугаа хүртүгэй

(*Голд шахан бууя.*

Хоньчин хургачин бидний

Хоолойяа хүртүгэй”) ^{тодосгогч} хэмээв.

Тэмүжин Жамухын энэ үгийг сонсоод ухаж ядаж, сэмээр байж хоцорч, нүүр думд тэргэдээн хүлцэж, (дүрсэлж тодруулан тодосгосон)

Булган дахын хариу

Бутарсан улсыг чинь

Бүгдгэлдэж өгсү

(*Хар булган дахын хариу*

Хагацсан улсыг чинь

Хамтатгалдаж өгсү.) ^{тодосгогч}

Ойролцоо утгатай зэргэдээр тодосгогч тодосгуулагчийн харьцаа үүсгэж, эрчимжүүлсэн утгатай. Утгын ойролцоо болон авианы ойролцоо байдлыг харгалзан тухайн эхийн үг өгүүлбэр, цогцолборыг харшуулан ойртуулах, толгой сүүл холбох, мөр бадаг тэнцүүлэх зэрэг найруулах эрдмийг чадамгай ашиглаж тодосгогч нэгжийг ашигласан. МНТ-ноос оноосон нэр, өргөмж нэр, газар усны нэрийг хоршин давтсан жишээ олонтоо харж болно. Хоршсон бүтцийг холбоостой ба холбоосгүйгээр харж болох ба олонтоо хэрэглэсэн холбоос нь “хэмээх” гэсэн холбох үг. Охин *Бархаг*, Бартан *баатар*, Хутугту *Мөнгүр*, Хутулу *хаан*, Төдөгэн *Отчигин* (МНТ, 21т) Тэмүжин Гарсу хэмээх *морио* хөтөлж айсахуйд..., ах дүү чинь амаан, *шүдээн* билүүдэн айсуй. (41т)

Үжин *эх* хоёр хүүхдийнхээ царай ухаж, \хэлний бус хэрэглүүр\

өгүүлрүүн:.. ижлээ идэгсэд, *ханиа барагсад*...(МНТ,37т)

хань ижил – *идэгсэд, барагсад*

... дайр, бор хоёр хүлэг *агтаст* бүлгээ. \Хоёр гэсэн тооны нэр холбох үгийн үүрэгтэй\

(Агта-агталсан морь, адуун сүрэг, хүлэг - алдартай, цуутай, “морь, агт” гэсэн үг хураагдаж, хүлэг морь, хүлэг агтас, хүлэг морь гэсэн хоршоо үг үүсэж, “хүлэг” гэсэн үгэнд зөвхөн морины утга үлдсэн байна) Ой инү орж амуй, *сэтгэл инү сэнхэрч амуй* \ой ухаан нь хурц, *бодол санаа нь бузгайрч буй* \97 тал\ Хоёр залуус та үзэлдэдхүн\ үргэлж бие биенээ үзэж нөхөрлөгтүн (МНТ,3 76т) хоёр гэсэн тодотголтой үгэнд “с” олон тооны дагавраар тодосгосон, та гэсэн эртний

монгол хэлний биеийн төлөөний олон тоот хэлбэрээр тодосгосон. Энэ нь хандсан утгатай.

Бурхан халдуны өвөрөө *Хүрэлху дотор Сэнгүр горхины Хар зүрхний Хөх нүүрт нутаглаж ахуйд* (МНТ, 43 т) *давхар тодосгосон*. Онон мөрний тэргүүнээ ^{бүхэл} Бурхан халдунаа ^{хэсэг} нутаглаж төрсөн Батачихан ажгуу. (*Тодруулан, дэлгэрүүлж тодосгосон. Ихэвчлэн монголчууд бүхлээс хэсэгчилдэг сэтгэлгээний соёл газар усны нэрэнд олонтоо ажиглагддаг.*)

Оруулбарт шинжтэй тодосгуулагч тодосгогчийн харьцааг авч үзвээс: Бас Алангоо таван хөвүүндээн сүюгэр үг өгүүллрүүн: *Та таван хөвүүн миний гагц хэвлээс төрөв...* гэх мэт оруулбарт шинжтэй эхээр тодосгосон жишээ 254 нүүрийн 38% -д байгаа нь уг зохиол дэлгэрүүлэн тодосгосон эхийн бүтцийг ашигласан. Энэ нь төдий хэр хүний хэлсэн үгийг эш татсан гэсэн үг. Давхар баймж утгын илэрхийлэмжийг ч тэмдэглэсэн байна.

ДҮГНЭЛТ

Тодосгогч нэгж өөрөө хэл, хэлэхүйг холбосон үзэгдэл бөгөөд МНТ хэлний нөгөө талаас хэлэхүйн чухал дурсгал. Тиймээс эртний үг хэллэгийн түгээмэл тайлбар бүхий эхээс ашигласан тодосгогч тодосгуулагчийн харьцааг эрсэн. Нүүр бүрт тодосгогч нэгж илэрсэн. Тодосгогч нэгжийг бүтээврээс эхлэн эхийн түвшинд авч тайлбарлах боломжтой.

Гадаад ертөнц хэлэн дэх ертөнцийн эх болохдоо байж болох бүх шинжүүдээр дэлгэрч сэтгэхүйн ертөнцөд боловсрогдоно гэж Н.Чомский хэлсэн байдаг. Тэр үед хэлэгдэхүүний нэг хэлбэр-дохио хосолдог байна. Сэтгэхүй дэх энэ боловсруулалт хоршсон хэлэгдэхүүний нэгжийг бий болгож хэлийг баяжуулдгийн жишээ МНТ-д олонтоо байгаа нь харагдаж байна.

НОМ ЗҮЙ

1. Актуальные проблемы текста, Улаан-Үдэ., 2004
2. Бабайцева, В.В., Максимов, Л.Ю., Современный русский язык, Синтаксис пунктуация, М., 1981
3. Базаррагчаа, М., Монгол хэлний өгүүлбэр судлал, Уб., 2005
4. Базаррагчаа, М., Монгол хэлний хоршоо үгийг хэрэглэх тухайд, Уб., 1990
5. Бат-Ирээдүй, Ж., Структура, семантика и функция синонимов в монгольском языке, (автореферат), Уб., 2004
6. Бат-Ирээдүй, Ж., Монгол хэлний хэлц үг хэллэгийн утга хэрэглээ, Уб., 2007
7. Барайшир, Ш., Өгүүлбэрийн тодосгогч гишүүний тухай асуудал, (ОУМЭ-ийн 4-р их хурал, 2-р боть) Уб., 1984
8. Монголын нууц товчоо (сонгомол эх)
9. Прагматик хэл шинжлэлийн онолын үндэс, хамтын бүтээл, Уб., 2007
10. Пүрэв-Очир, Б., Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүй, Уб., 2001

ABSTRACT

The Mongolian Language is rich in unit modifier and their function is immense. “The Secret History of the Mongols” is a literary and significant work of Mongolian history and culture. Many scientists and researchers of the world have been studying it in various aspects.

This paper was written for the purpose of briefly clarifying some usage modifiers related to parallel structure of the Secret History of Mongols. Parallel structure means using the same pattern of words to show that two or more ideas have the same level of importance. This can happen at the word, phrase or clause level. For example:

Khari ulsiig ul temtsen	(Uls irgeniig ul temtsen
Khatsar goo okhidiig	Ungu sait okhidoo usguj
Khasag tergend unuulj	Uljigtei tergend unuulj
Khar buur khulguj	Ul buur khulguj
Khatiruulj odoj	Uusgej odoj
Khatan suurind	Undur suurind
Khamt ssulgamui bid	Uruul etgeed suulgakhui bid) ^{modifier}

Another issue addressed in this paper is the usage of different modifiers in “The Secret History of the Mongols” has been explained from the point of psycholinguistics.